



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/273

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөвсгөл Аймгийн Галт, Жаргалант сумдад их хэмжээний цастай өвөлжилт хүндэрсэн тул нөхцөл байдалтай уялдуулан малчдад өвс, тэжээл хүргэх зардлын үнэ Галт суманд 4 500 000 (Дөрвөн сая таван зуун мянган), Жаргалант суманд 3 500 000 (Гурван сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Мал хамгаалах сангаас зарцуулсугай.

2. Дээрх сумдын хаваржилтын нөхцөл байдалтай танилцахад зарцуулагдсан шатахууны зардал 1 000 000 (Нэг сая) төгрөгийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт олгосугай.

3. Дээрх сумдын үүссэн нөхцөл байдалтай уялдуулан гарсан зардал болох 9 000 000 (Есөн сая) төгрөг зарцуулахыг аймгийн Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Я.Баянжаргал)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД